

БАТЛАВ:
ЗАСАГ ДАРГА

Л.ТӨМӨРЧӨДӨР

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

№03

Энэхүү гэрээг нэг талаас Төв аймаг Сэргэлэн /сум/-ын Засаг дарга Л.ТӨМӨРЧӨДӨР (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “НОЁН ТОХОЙ ТРЕЙД ХХК”(цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Төв /аймаг/ Сэргэлэн /сум/ -нд байгуулав..

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Талуудын энэхүү гэрээгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уурхайн ашиглалт, үйлдвэрлэлтэй холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг харилцан уялдаатай хөгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гэрээний хугацаанд хамтран хэрэгжүүлэх ажлын төрөл, хугацааны талаар харилцан зөвшилцөж, хийгдэх ажлын жагсаалтыг баталж хэрэгжүүлнэ.

1.2 Энэхүү гэрээгээр уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах чиглэлээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах, аймаг, орон нутгийн хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3 Энэхүү гэрээг 2007 оны 02 сарын 09 ны өдөр олгогдсон MV-007039 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулна.

1.4 Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 25.3-т заасан хэмжээгээр тодорхойлогдоно.

Хоёр. Хамтын ажиллагааны зарчим

- 2.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах
- 2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, хариуцлагатай ажиллах
- 2.4 Талууд нь бие биенийхээ ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, хуулийг дээдлэх

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1 Нутгийн захиргааны байгууллагын эрх үүрэг

3.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

3.1.2. Энэхүү гэрээний хүрээнд хэрэгжүүлэх ажлыг дэмжих, хамтарч ажиллах, орон нутгаас хамааралтай бэлтгэл ажлыг хангах, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй давхцуулахгүй байх талаар хяналт тавих.

3.1.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, саналыг нь авах, Гэрээний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр дүгнэж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнах

3.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

3.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

3.1.7 Гэрээнд заагаагүй ажил, санхүүжилтийг болон хуульд заагдаагүй татвар, төлбөр хураамжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахгүй байх

3.1.8 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардах

3.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.2.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

- 0-га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байх
- 2-га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байх
- 5-га дүйцүүлэн хамгаалах

Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, чиглэлээр:

- Нутгийн захиргааны байгууллагатай хамтран орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулсан байдал.
- Орон нутгийн хөгжлийн санд/10.000.000/
- 2023 онд “Тэрбум мод тарьж ургуулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд өөрийн эзэмшлийн талбайд 500ш мод

Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр:

- 4 иргэнийг байнгын ажлын байраар хангах
- 15 иргэнийг түр ажлын байраар хангах.

Уурхайн хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр:

- Мах, сүүний хэрэгцээг 100% хангана. / 2 тн мах авна./
- Хүнсний ногооны хэрэгцээг хангана. / 1 тн төмс, 1 тн хүнсний ногоо/
- Ажлын хувцасны хэрэгцээг хангана.

3.2.6 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.2.7 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.2.8 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, нутгийн иргэдэд хагас, бүтэн жилээр мэдээлэл өгч ажиллах

Дөрөв. Гэрээний хэрэгжилт

4.1. Талууд гэрээг тухайн жилийн 1-р улиралд багтаан Сумын засаг даргатай байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

4.2 Талууд гэрээний хэрэгжилтийг сум орон нутагтаа хагас бүтэн жилээр дүгнэж сумын ИТХ-аар баталгаажуулан, хагас жилийн хэрэгжилтийг 07 сарын 20-ны дотор, жилийн эцсийн хэрэгжилтийг дараа оны 02 сарын 15-ны дотор Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлнэ.

4.3 Орон нутагтай байгуулсан Нийгмийн хариуцлагын гэрээний хагас бүтэн жилийн хэрэгжилтийг хавсралтад заасны дагуу Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс 02 сарын 20-ны дотор дүгнэж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ИТХ-д танилцуулна.

Тав. Гэрээний хариуцлага

5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

Зургаа. Бусад

6.1 Гэрээ байгуулагч аж ахуй нэгжийн хандив дэмжлэг туслалцаатайгаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн салбаруудын хөгжлийг тодорхойлсон бодлогын баримт бичигт тусгагдаж тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр баталгаажна.

6.2 Санхүүжүүлэх эх үүсвэр дутагдсанаас хандив, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, бусад холбогдох мэдээллийг гэрээ байгуулах аж ахуйн нэгжүүдэд урьдчилан хүргүүлж танилцуулан, хэрэгжүүлэх эсэхийг зөвхөн аж ахуйн нэгжийн саналаар сонгуулан зөвшилцөн тохиролцсон байна.

Долоо. Маргаан шийдвэрлэх

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.


8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг 3 хувь үйлдэж хувийг нутгийн захиргааны байгууллага, дээд шатны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид тус тус хүргүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ
СУМЫН БАЙГАЛ ОРЧНЫ
АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

.....


/П.Батболд /
Утас:88042747



..... /
Утас: 88115786